



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/130

Чингис хот

Мал амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх,
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг 2021 оны 04-р сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Шимэгчтэх өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн графикт хугацаанд нь орон нутагт чанартай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, мал угаалгын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, эрчимжүүлж ажиллахыг Онцгой комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Сум хариуцан ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралт, 2021 онд шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, амьтны тоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Уг арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах, угаалга, туулгалт, боловсруулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийж мэргэжлийн байгууллагын заавар журмыг баримтлаагүй малчин, мал бүхий иргэд, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллан дүнг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний дотор танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010359

Сум хариуцан ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүд

Д/Д	Сумын нэр	Гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галшар	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
2	Баянхутаг	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга
3	Баянмөнх	О.Од-Эрдэнэ	Мэдээлэл холбоо сүлжээний газрын дарга
4	Дархан	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
5	Дэлгэрхаан	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
6	Жаргалтхаан	Ж.Энх-Амгалан	Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга
7	Цэнхэрмандал	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
8	Өмнөдэлгэр	Ч.Дүрэвдорж	Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Ч.Ариунаа	БЭӨБЦТССүлжээ ТӨК-н дарга
10	Биндэр	Б.Ганбат	АТГ-ын дарга, оношлогоо
11	Баян-Адрага	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
12	Дадал	Б.Хэрлэнчимэг	УЦУОШТ-ийн дарга
13	Норовлин	С.Мөнхцэцэг	Бсловсрол, соёл урлагийн газрын дарга
14	Батноров	Ч.Батгэрэл	Цахилгаан холбооны газрын дарга
15	Баян-Овоо	Г.Наранхүү	ЗӨСТөвийн дарга
16	Мөрөн	Ж.Гантулга	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
17	Хэрлэн	М.Шүрэнцэцэг	Чингис хотын захирагч бөгөөд Хэрлэн сумын Засаг дарга
18	Бор-Өндөр	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын..... өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

2021 ОНД ШИМЭГЧТЭХ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНД ХАМРУУЛАХ МАЛ, АМЬТНЫ ТОО/ мянган толгойгоор/

Д/д	Сумын нэр	Угаалга/мян.тол/				Туулгалт/мян.тол/				Боловсруулалт /мян.тол/			Гуурын боловсруулалт т/мян.тол/		Дүн
		Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Бод	Бог	Нохой	Бүгд	Бод	Бог	Бүгд	Үхэр	Бүгд	
1	Галшар	19.2	170.1	107.6	296.9	3.8	56.6	0.3	60.7	1.9	28.6	30.5	19.2	19.2	407.3
2	Баянхутаг	20.2	223.5	110.0	353.7	7.0	100.0	1.0	108.0	4.0	50.0	54.0	20.2	20.2	535.9
3	Баянмөнх	11.3	102.5	64.6	178.4	2.2	36.0	0.3	38.5	1.7	17.0	18.7	11.3	11.3	246.9
4	Дархан	10.7	139.2	97.0	246.9	2.2	46.9	0.2	49.3	1.2	23.6	24.8	6.0	6.0	327.0
5	Дэлгэрхаан	16.5	122.6	104.1	243.2	3.3	47.7	0.5	51.5	1.7	24.0	25.7	16.5	16.5	336.9
6	Жаргалтхаан	12.6	115.0	81.3	208.9	2.7	45.0	0.4	48.1	2.5	63.0	65.5	12.6	12.6	335.1
7	Цэнхэрмандал	21.0	121.8	81.2	224.0	4.2	40.6	0.5	45.3	2.1	20.3	22.4	21.0	21.0	312.7
8	Өмнөдэлгэр	43.1	307.7	244.2	595.0	19.6	117.7	1.6	138.9	4.6	57.4	62.0	43.1	43.1	839.0
9	Батширээт	21.9	31.6	20.1	73.6	4.4	10.5	0.9	15.8	7.0	19.0	26.0	21.9	21.9	137.3
10	Биндэр	37.5	108.8	88.9	235.2	8.0	42.1	0.6	50.7	4.0	29.6	33.6	37.5	37.5	357.0
11	Баян-Адарга	16.6	93.3	65.7	175.6	3.3	40.0	0.3	43.6	3.0	50.0	53.0	16.6	16.6	288.8
12	Дадал	20.5	13.5	13.3	47.3	4.0	5.9	0.2	10.1	2.4	2.6	5.0	20.5	20.5	82.9
13	Норовлин	25.2	88.8	62.1	176.1	4.7	29.9	0.15	34.75	2.7	20.3	23.0	25.2	25.2	259.1
14	Батноров	30.3	222.3	126.5	379.1	7.0	83.4	0.9	91.3	3.0	41.7	44.7	30.3	30.3	545.4
15	Баян-Овоо	16.9	94.6	60.4	171.9	4.2	50.2	0.2	54.6	4.1	50.5	54.6	16.9	16.9	298.0
16	Мөрөн	11.6	97.1	73.0	181.7	2.9	42.5	0.5	45.9	3.5	51.0	54.5	11.6	11.6	293.7
17	Хэрлэн	34.9	252.7	186.3	473.9	7.4	85.0	1.2	93.6	4.2	52.7	56.9	34.9	34.9	659.3
18	Бор-Өндөр	2.5	31.0	31.0	64.5	0.7	29.5	0.16	30.4	0.3	26.0	26.3	3.0	3.0	124.2
Дүн.		372.5	2336.1	1617.3	4325.9	91.6	909.5	9.91	1011.0	53.9	627.3	681.2	368.3	368.3	6386.4